

Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал
(2016 оны эхний 10 сарын байдлаар)



I. Нийгмийн байдал

I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 2016 оны 10 сард 313 байгаагийн 214 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 121 буюу 27.9 хувиар, өмнөх сарынхаас 2 буюу 0.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



II. Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 10 сард 6321.3 сая төгрөг, зарлага 7372.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 135.2 сая төгрөг буюу 2.2 хувиар, зарлага 127.2 сая төгрөг буюу 1.8 хувиар тус тус өслөө.



III. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 10 сарын байдлаар 384 эх амаржиж 2015 оны мөн үетэй харьцуулахад 21 буюу 5.8 хувиар төрөлт нэмэгдсэн байна. Амьд төрсөн хүүхэд 387 үүнээс 193 нь хүү, 194 нь охин байна. Өмнөх оны мөн үеийнхээс амьд төрсөн хүүхэд 22 буюу 6.0 хувиар тус тус өссөн байна.



IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 10 сард 168 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 5 буюу 2.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.



VII. Орон нутгийн төсөв

2016 оны эхний 10 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 20761.3 сая төгрөг, гүйцэтгэлээр 21086.9 сая төгрөг болж орлогын төлөвлөгөө 101.6 хувийн биелэлттэй байна.



VIII. Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд 2015 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 171188 хээлтэгч малын 151504 буюу 88.5 хувь нь төллөсөн байна. Эм хонины 92.2 хувь, эм ямааны 86.5 хувь, үнээний 81.9 хувь, ингэний 52.4 хувь, гүүний 74.2 хувь нь төллөсөн бөгөөд 2016 оны 10 сарын байдлаар 149294 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 17281 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна. Төл бойжилт 97.8 хувьтай байна.



VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт гаргалт 2016 оны эхний 10 сард 35552.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 5795.2 сая төгрөг буюу 20.2 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарын гаргалт нь 5928.9 сая төг буюу 21.0 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 33745.5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4229.8 сая төгрөг буюу 14.3 хувиар өслөө.



IX. ТЭЭВЭР

Авто тээврийн үндэсний төвийн 2016 оны эхний 10 сарын мэдээгээр 20.0 мянган зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 4550.2 мян.хүн км болж, 13 ажилтантай 11.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал зорчигч тээвэрлэлт 6.4 хувиар, зорчигч эргэлт 8.4 хувиар, тээврийн орлого 3.6 хувиар тус тус өссөн үзүүлэлт гарлаа.

X. ХОЛБОО

Аймгийн холбооны газрын мэдээгээр 2016 оны эхний 10 сарын байдлаар нийт орлого 167.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 14.7 сая төг буюу 8.1 хувиар буурчээ. Нийт орлогод хүн амаас орсон орлого 100.5 сая төг буюу 60.1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 0.6 сая төг буюу 0.6 хувиар өссөн байна. Аймгийн хэмжээнд нийт суурин телефон цэгийн тоо 343 болж өмнөх оны мөн үеийнхээс 50 буюу 12.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



XI. Цаг агаарын мэдээ

Хур тунадас: Энэ сард нийт 11.3 мм хур тунадас орсон.

Салхи: Ихэнх хугацаанд секундэд 5-11 метр байсан.

Агаарын температур: 10-р сарын 1-р арав хоног болон 2-р 10 хоногийн дунд болон сүүлээр шөнөдөө 3 градус хүйтнээс 2 градус дулаан, өдөртөө 11-16 градус дулаан, 2-р арав хоногийн эхэн болон 3-р арав хоногийн эхэн үеэр шөнөдөө 3-8 градус хүйтэн, өдөртөө 2-7 градус дулаан, бусад хугацаанд шөнөдөө 14-19 градус хүйтэн, өдөртөө 4-8 градус хүйтэн байсан. Хамгийн дулаан нь 2-ны өдөр 16.0 градус дулаан, хамгийн хүйтэн нь 30-ны шөнө 19.6 градус хүйтэн байсан байна.